

## COURSE: INTRODUCTION TO INFORMATION SYSTEM

## WEEK 16: Midterm 2

Шалгалтын үргэлжлэх хугацаа: 40 минут

- ..... нь бага эрсдэлтэй бөгөөд илүү хурдан нэвтрүүлэлт рүү хөтөлдөг боловч засвар үйлчилгээ, дэмжлэгийн зардал нь үнэтэй болдог.  
A) Custom (өөртөө зориулсан) програм хангамж  
B) Энтерпрайс програм хангамж  
C) Бэлэн програм хангамж  
D) Хувийн бүтээмжийн програм хангамж
- ..... програм хангамж нь байгууллагын өнөөгийн ажлын явцтай илүү нийцэж, өрсөлдөөний давуу талыг бий болгож чадах боловч програм хангамжийн хөгжүүлэлтийн өртөг зардал өндөр, байхаас гадна дуусгахад хэдэн сар эсвэл бүр хэдэн жил зарцуулж болно.  
A) Custom (өөртөө зориулсан) програм хангамж  
B) Энтерпрайс програм хангамж  
C) Бэлэн програм хангамж  
D) Хувийн бүтээмжийн програм хангамж
- Ихэнх байгууллага судалгаа хийх, шинжлэх, ....., байгуулах, нэгтгэх (интеграцлах) ба тестлэх, нэвтрүүлэх гэсэн зургаан үе шаттай хүрхрэн хандлагыг ашигладаг.  
A) Зохиомжлох  
B) Хөгжүүлэх  
C) Турших  
D) Сонголт хийх
- Системийн судалгааны үе шатны зорилго нь:  
A) Асуудлыг шийдэхийн тулд эсвэл таатай боломжийг ашиглахын тулд мэдээллийн систем юу хийх ёстойг тодорхойлох  
B) Шийдэх шаардлагатай асуудлын онцлог мөн чанарын эсвэл анхаарал хандуулах шаардлагатай таатай боломжийн талаар тодорхой ойлголттой болох  
C) Одоогийн системд байгаа өгөгдлийг цуглуулж, шинэ системийн шаардлагуудыг тодорхойлох  
D) Системийн шаардлагуудыг тодорхойлж, баталгаажуулах, зэрэглэх
- Системийн .....ерөнхий зорилго нь одоогийн системийн мэдээллийг цуглуулж, шинэ системд тавих шаардлагуудыг тодорхойлох, тодруулсан шахалт хязгаарлалтын хүрээнд хувилбарт шийдлүүдийг тодорхойлох, хувилбарт шийдлүүдийн хэрэгжих боломжийг судлахад төвлөрдөг.  
A) Судалгааны  
B) Шинжилгээний  
C) Зохиомжийн  
D) Тестийн
- ..... бол одоогийн багц програмууд нь байгууллагын хэрэгцээг хангаж чадах эсэхийг тодорхойлох програм хангамжийн зах зээлийг үнэлэх үндсэн хэрэгсэл юм.  
A) Системийн судалгааны тайлан  
B) Үнийн санал авах хүсэлт (RFQ)  
C) Мэдээлэл авах хүсэлт (RFI)  
D) Системийн зохиомжийн тайлан
- Систем ..... үе шат нь програмын кодыг бичиж тестлэх, өгөгдөл үүсгэж, өгөгдлийн санд ачааллах, програмын эхний шатны тестийг гүйцэтгэх замаар системийн зохиомжийг ажилладаг систем болгон хувиргана  
A) Системийн шинжилгээ хийх  
B) Системийг байгуулах  
C) Системийг нэвтрүүлэх  
D) Системийг нэгтгэх ба тестлэх
- Хоёр эсвэл гурван хүчтэй өрсөлдөгч програмуудыг тодорхойлсон үед ..... үе шатанд програм хангамжийн багц болон борлуулагчдын урьдчилсан үнэлгээ эхэлдэг.  
A) Системийн судалгаа  
B) Системийн зохиомж  
C) Системийн шинжилгээ  
D) ТЭЗҮ-ийн буюу хэрэгжих боломжийн шинжилгээ

9. .... үе шатан дээр мэдээллийн системийн техник хангамж, програм хангамж, өгөгдлийн сангийн систем, харилцаа холбоо, интернэтийн үйл ажиллагаа зэрэг бүх талд системийн онцлог аюулгүй байдал, хяналтыг боловсруулна.
- A) Системийн судалгаа
  - B) Системийн зохиомж
  - C) Системийн шинжилгээ
  - D) Системийн нэвтрүүлэлт
10. Аль нь зөвхөн нэг бүлэг хэрэглэгчдэд шинэ системийг бүрэн нэвтрүүлэх замаар хуучин мэдээллийн системээс шинэ систем рүү шилждэг процесс вэ?
- A) Шууд нэвтрүүлэх
  - B) Үе шаттай хөрвүүлж нэвтрүүлэх
  - C) Туршин нэвтрүүлэх
  - D) Параллелаар нэвтрүүлэх
11. Хэрэглэгчдийн болон байгууллагын зорилгод хүрэхэд нь илүү үр дүнтэй болгохын тулд системийг өөрчлөх, сайжруулах үйл явц аль үе шатанд хийгддэг вэ?
- A) Системийн шинжилгээ
  - B) Системийн зохиомж
  - C) Системийн нэвтрүүлэлт
  - D) Системийг ажиллуулах ба завсар үйлчилгээ
12. Үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийн хоорондох дундын зуучлагчийг багасгадаг хэлбэрийг ..... гэж нэрлэдэг
- A) B2B
  - B) B2C
  - C) C2C
  - D) G2C
13. Ardshop нь аль орлогын загварт хамаарах вэ?
- A) Борлуулалтын
  - B) Freemium
  - C) Гүйлгээний хураамжинд суурилсан
  - D) Хамтрах, нөхөрлөх
14. Ebarimt нь аль хэлбэрт хамаарах вэ?
- A) G2C
  - B) B2G
  - C) B2B
  - D) C2G
15. Аль нь электрон худалдаанд тулгамддаг гол асуудал биш вэ?
- A) Хэрэглэгчийн нууцлалын асуудлыг шийдвэрлэх
  - B) Хэрэглэгчийн итгэлийг олж авах
  - C) Глобал асуудлуудыг даван туулах
  - D) Глобал зах зээлд хандах хэрэглэгчийн сонирхол бага бөгөөд үнийн өрсөлдөөн
16. Компаний вэб сайтууд нь дараах шинж чанаруудаас алийг нь багтаасан байх хэрэгтэй вэ
- A) Хэрэглэхэд хялбар
  - B) Компаний зорилгыг биелүүлэхэд чиглэсэн
  - C) Сайжруулах засварлах боломжтой байх
  - D) Дээрх бүгд зөв
17. Вэб сайтыг өөрсдийн нөөц боломжиндоо тулгуурлан хөгжүүлэхээр шийдсэн бол аль ангилалд хамаарах вэ?
- A) In-House
  - B) Outsource
  - C) Storefront broker
  - D) Blended
18. Bsb.mn сайт нь орлогын ямар загварт хамаарах вэ?
- A) Зар сурталчилгааны
  - B) Борлуулалтын
  - C) Захиалгын
  - D) Гүйлгээний хураамжинд суурилсан
19. Вэб сайтыг хурдыг хэмжих гол үзүүлэлтүүдийг сонгоно уу
- A) Хариу өгөх хугацаа
  - B) Хандаж буй хэрэглэгчдийн тоо
  - C) Хайлт хийсэн тоо
  - D) Google илэрцэд илрэх эрэмбэ
20. Вэб серверийн тооцоолох хүчин чадал, хадгалалтын багтаамжийг ..... тулгуурлан сонгодог
- A) Серверийн газарзүйн байршил ба хэр олон төрлийн бүтээгдэхүүн борлуулагдаг дээр
  - B) Сервер дээр ажиллаж буй програм хангамж болон э-худалдааны гүйлгээний хэмжээн дээр
  - C) Бизнесийн байгууллагын хэмжээ болон хэрэглэгчийн газар зүйн байршил дээр
  - D) Боломжит хэрэглэгчдийн тоо болон гүйлгээ бүрт хийгдэх дундаж мөнгөн дүн дээр

21. Э-худалдааны технологийн дэд бүтцийг зөв тодорхойлсонг сонгоно уу  
 А) Серверийн компьютер, серверийн үйлдлийн систем, серверийн програм хангамж, э-худалдааны вэб сайтын програм  
 В) Серверийн компьютер, утасгүй сүлжээ, дэлгэж, серверийн програм хангамж  
 С) Серверийн компьютер, серверийн үйлдлийн систем, домэйн, өгөгдлийн сан  
 D) Серверийн үйлдлийн систем, серверийн програм хангамж, э-худалдааний вэб сайтын програм, домэйн
22. Байгууллага суурьтай төлбөр тооцооны хэрэгсэлд аль нь багтахгүй вэ?  
 А) Sandy  
 В) PayPal  
 С) Зэс карт  
 D) Alipay
23. Электрон худалдааны програм хангамжийн зайлшгүй гүйцэтгэдэг байх ажил даалгаварт аль нь багтахгүй вэ?  
 А) Хэрэглэгчтэй харилцах онлайн чат  
 В) Сагсны удирдлага  
 С) Каталог удирдлага  
 D) Бүтээгдэхүүний тохиргоо
24. .... нь компьютерын сүлжээгээр дамжуулан бизнесийн үйл ажиллагааг (түгээх, борлуулах, худалдан авах, маркетинг, үйлчилгээ) электрон хэлбэрээр явуулахыг хэлнэ  
 А) B2B  
 В) B2C  
 С) C2C  
 D) Электрон худалдаа
25. Аль нь халдлага эсэргүүцэх технологид орохгүй вэ?  
 А) Криптограф  
 В) Антивирус  
 С) Нэг удаагийн нууц үг  
 D) Firewall
26. .... нь хэрэглэгчид найдвартай эх сурвалжаас хууль ёсны програм ашиглаж буй мэт сэтгэгдэл төрүүлэн компьютерт халддаг.  
 А) Вирус  
 В) Өт  
 С) Trojan horse  
 D) Ransomware
27. Эцсийн хэрэглэгчийн зөвшөөрөлгүй компьютерын админы хандах эрхийг авахыг зорьдог багц програмуудыг юу гэдэг вэ?  
 А) Zombie  
 В) Rootkit  
 С) Botnet  
 D) Blended threat
28. .... үе шатанд байгууллагын компьютер болон сүлжээнд гадаад, дотоод эх үүсвэрээс бий болгох аюулуудыг тодорхойлон үнэлдэг.  
 А) Урьдчилан сэргийлэх  
 В) Халдлагыг илрүүлэх  
 С) Эрсдэлийг үнэлэх  
 D) Аюулгүй байдлын дүрэм журмыг боловсруулах
29. Байгууллагын дотоод сүлжээ болон интернэтийн хооронд байгууллагын хандах эрхийн дүрэм журамд үндэслэн сүлжээний хандалтыг аль нь хязгаарладаг вэ?  
 А) Рүтер  
 В) Worm hole  
 С) Халдлага илрүүлэх систем  
 D) Галт хана
30. .... халдлага илрүүлэх систем нь тодорхой төрлийн халдлага болон системийн найдваргүй байдлын мэдээллийг хадгалсан байх ба эдгээр халдлагууд илрэх эсэхийг хянаж байдаг.  
 А) Зан төлөвт суурилсан  
 В) Мэдлэгт суурилсан  
 С) Үйл явдалд суурилсан  
 D) Архивт суурилсан
31. Тухайн програмын байтуудын дэс дарааллыг шалгадаг програм хангамжийг юу гэж нэрлэдэг вэ?  
 А) Галт хана  
 В) Анти-вирусны програм  
 С) Халдлага илрүүлэх систем  
 D) Аудитын програм
32. Санхүүгийн залилангийн зорилгоор компьютер болон сүлжээнд нэвтэрч буй халдлага үйлдэгч нь аль ангилалд хамаарах вэ?  
 А) Cybercriminal  
 В) Hacker  
 С) Cracker  
 D) Malicious insider

33. Хэрэглэгчдийн эрхийн түвшинд хязгаарлалт хийх, ажлаас гарсан ажилчдын эрхийг идэвхгүй болгох зэрэг ямар хэлбэрийн урьдчилан сэргийлэх аргад хамаарах вэ?
- A) Аюулгүй байдлын хяналтын самбар
  - B) Интернэтийн аюулгүй байдлыг шийдвэрлэх
  - C) Аудитын тогтмол шалгалт
  - D) Дотоодын халдлагаас хамгаалах
34. Доорх зөвлөмжүүдээс аль нь өөрийгөө кибер гэмт хэргээс хамгаалахад туслах вэ?
- A) Өөр өөр вэб сайтуудад болон хэрэглээний програмууд дээр өөр өөр нууц үгнүүдийг хэрэглэ
  - B) Үйлдлийн системийн бүх хамгаалалтыг суулгаж, шинэчилж байх
  - C) Вэб браузер, имэйлийн болон бусад програмуудын хамгийн сүүлийн үеийн хувилбарыг хэрэглэх
  - D) Дээрх бүгд зөв
35. Байгууллагын дотоод үнэлгээ ба түүний гадаад орчны шинжилгээг гол төлөв .....-ны матрицад нэгтгэдэг.
- A) SWOT шинжилгээ
  - B) Асуудлын шинжилгээний
  - C) Шалтгаан ба үр нөлөөний шинжилгээний
  - D) Амжилтын хүчин зүйлсийн шинжилгээний
36. Доорх жишээний аль нь бодит үр өгөөжийн тодорхой жишээ болж чадах вэ?
- A) Ажилчдын шагнал, тэтгэмжийн өөртөө үйлчлэх програм хангамжийн багцыг нэвтрүүлснээр ажиллагчдын ёс суртахуун сайжрах
  - B) Цалингийн системийг сайжруулсны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн алба нэгжийн ажиллагчдын тоо бууруулах
  - C) Байгууллагын Вэбсайтад өөрчлөлт хийснээр хэрэглэгчийн сэтгэл ханамж дээшлэх
  - D) Өөрөө шинжилгээ хийх хэрэгслүүдийн үр дүнд шийдвэр гаргалт сайжрах
37. МС-ийн бүх төслийн ..... нь сорилттой тулгарч эсвэл бүтэлгүйтэж байна
- A) 25-аас бага хувь
  - B) Бараг тал нь
  - C) Ойролцоогоор 71 хувь
  - D) 80-аас дээш хувь
38. .... бол өвөрмөц бүтээгдэхүүн, үйлчилгээ, үр дүнг бий болгох түр зуурын үйл ажиллагаа юм.
- A) Эрхэм зорилго
  - B) Зорилт
  - C) Стратеги
  - D) Төсөл
39. Хамрах хүрээ, зардал, цаг хугацаа, ....., болон хэрэглэгчдийн хүлээлт гэсэн хоорондоо маш уялдаа холбоотой таван үзүүлэлт нь төслийг тодорхойлдог.
- A) Чанар
  - B) Шаардлагууд
  - C) Хөрөнгө
  - D) Үйл явц